



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/76/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот
2021он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: ganulzii.t@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ш.Нарантуяа

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Гэрэлт хөхийн тэнцвэр
Аудит” ХХК

Утас: 9611-2118 Цахим хаяг: Gerelt.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Аудитын зөвлөмж:	<u>17</u>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.25 № 16/145

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН АГАТОВА
ӨРХИЙН ЭМНЭЛГИЙН ДАРГА
О.УРАНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,082,916.91	51,017,573.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,863.41	4,025,965.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,863.41	4,025,965.55
3121	Төгрөг	18,863.41	4,025,965.55
31211	Төрийн сангийн харилцах	18,863.41	4,025,965.55
35	БАРАА МАТЕРИАЛ	33,064,053.50	46,991,607.54
351	Түүхий эд материал	16,126,372.50	24,335,238.54
35110	Тусгай зориулалттай материал	8,711,108.00	10,792,608.00
35130	Эм боох материал	7,415,264.50	13,542,630.54
354	Хангамжийн материал	16,937,681.00	22,656,369.00
35410	Бичиг хэргийн материал	2,385,010.00	3,011,520.00
35420	Аж ахуйн материал	14,244,763.00	19,323,478.00
35430	Сэлбэг хэрэгсэл	272,000.00	152,000.00
35440	Түлш, шатах тослох материал	35,908.00	169,371.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,143,680.02	49,117,572.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,143,680.02	49,117,572.63
392	Биет хөрөнгө	17,143,680.02	49,117,572.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,655,000.00	21,855,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,655,000.00	-7,710,555.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,472,474.93	65,666,374.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,612,443.66	-44,115,102.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,064,273.00	18,063,273.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,634,570.33	-7,318,531.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,231,800.00	3,164,048.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-607,339.92	-716,420.60
39217	Ном	229,486.00	229,486.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	50,226,596.93	100,135,145.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	50,226,596.93	100,135,145.72
51	Засгийн газрын хувь оролцоо	50,226,596.93	100,135,145.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,656,634.00	82,656,634.00
51101	Өмч: - төрийн	82,656,634.00	82,656,634.00
512	Хуримтлагдсан үр дүн	-32,665,967.97	17,242,580.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-32,665,967.97	-32,665,967.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	49,908,548.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	235,930.90	235,930.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	50,226,596.93	100,135,145.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	150,228,352.79	304,132,398.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	797,542.79	75,401,390.91
120	Нийтлэг татварын бус орлого	797,542.79	75,401,390.91
120002	Хүүгийн орлого	27,708.79	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	769,834.00	75,401,390.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	29,409,760.26
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	769,834.00	45,991,630.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,868,010.00	32,376,008.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	117,562,800.00	196,355,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,220,000.00	10,187,408.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,220,000.00	10,187,408.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,648,010.00	22,188,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,648,010.00	22,188,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	147,396,746.27	254,198,250.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,396,746.27	254,198,250.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,541,746.27	250,718,207.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,116,399.00	166,409,698.00
210101	Үндсэн цалин	87,778,399.00	142,244,321.00
210102	Нэмэгдэл	00.00	10,307,635.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,338,000.00	8,709,000.00
210104	Урамшуулал	00.00	5,148,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,532,845.63	10,710,283.73
210201	Тэтгэврийн даатгал	8,694,923.63	5,700,315.13
210202	Тэтгэмжийн даатгал	821,241.00	708,025.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	965,780.00	807,655.00
210204	Ажилгүйдлийн даатгал	186,446.00	161,595.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,864,455.00	3,332,693.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,950,188.63	12,429,420.86
210301	Гэрэл, цахилгаан	466,348.63	584,392.86
210302	Түлш, халаалт	10,187,408.00	10,187,408.00
210303	Цэвэр, бохир ус	1,296,432.00	1,657,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,840,034.60	8,490,475.50
210401	Бичиг хэрэг	1,746,520.00	3,161,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,972,902.00	1,907,417.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	592,518.00	649,382.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	192,417.60	211,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	2,335,677.00	2,560,176.50

**Дорноговь аймгийн Сайншанд Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	зүйлс		
2105	Нормативт зардал	9,545,801.35	44,532,716.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,545,801.35	44,532,716.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,000.00	1,130,250.00
210604	Урсгал засвар	160,000.00	1,130,250.00
2107	Томилолт, зочны зардал	159,300.00	168,100.00
210702	Дотоод албан томилолт	159,300.00	168,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,954,105.38	1,318,957.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,611,030.12	930,847.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,800.00	25,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	97,875.26	96,810.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,283,071.68	5,528,305.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	834,900.00	864,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	343,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,448,171.68	4,320,055.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	855,000.00	3,480,043.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	855,000.00	3,480,043.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	855,000.00	3,480,043.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,831,606.52	49,934,148.79
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,872,991.90	25,600.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,872,991.90	25,600.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-19,872,991.90	-25,600.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-17,041,385.38	49,908,548.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	149,458,518.79	258,140,768.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,708.79	29,409,760.26
120	Нийтлэг татварын бус орлого	27,708.79	29,409,760.26
120002	Хүүгийн орлого	27,708.79	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	29,409,760.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	29,409,760.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	149,430,810.00	228,731,008.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	117,562,800.00	196,355,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,220,000.00	10,187,408.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,220,000.00	10,187,408.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,648,010.00	22,188,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,648,010.00	22,188,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	148,827,284.99	234,971,966.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	148,827,284.99	234,971,966.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,892,284.99	231,372,603.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,116,399.00	166,409,698.00
210101	Үндсэн цалин	87,778,399.00	142,244,321.00
210102	Нэмэгдэл	00.00	10,307,635.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,338,000.00	8,709,000.00
210104	Урамшуулал	00.00	5,148,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,532,845.63	10,710,283.73
210201	Тэтгэврийн даатгал	8,696,287.63	6,985,047.13
210202	Тэтгэмжийн даатгал	904,861.00	441,776.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	880,796.00	490,594.00
210204	Ажилгүйдлийн даатгал	186,446.00	115,421.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,864,455.00	2,677,445.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,950,188.63	12,429,420.86
210301	Гэрэл, цахилгаан	466,348.63	584,392.86
210302	Түлш, халаалт	10,187,408.00	10,187,408.00
210303	Цэвэр, бохир ус	1,296,432.00	1,657,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,506,874.60	10,219,507.00
210401	Бичиг хэрэг	1,385,600.00	2,799,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,902,150.00	1,814,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	592,518.00	649,382.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	492,417.60	236,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,114,189.00	4,698,595.00
2105	Нормативт зардал	14,736,871.75	19,427,391.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,570,071.75	17,210,755.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,800.00	2,216,636.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	310,300.00	8,594,085.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	5,814,500.00

**Дорноговь аймгийн Сайншанд Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210604	Урсгал засвар	310,300.00	2,779,585.00
2107	Томилолт, зочны зардал	159,300.00	168,100.00
210702	Дотоод албан томилолт	159,300.00	168,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,654,105.38	1,368,957.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,289,030.12	980,847.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,800.00	25,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	97,875.26	96,810.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	925,400.00	2,045,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	925,400.00	1,701,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	343,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	935,000.00	3,599,363.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	935,000.00	3,599,363.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	935,000.00	3,599,363.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>631,233.80</u>	<u>23,168,802.14</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	650,000.00	19,161,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	650,000.00	19,161,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	650,000.00	19,161,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	650,000.00	19,161,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-650,000.00</u>	<u>-19,161,700.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-18,766.20	4,007,102.14
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,629.61	18,863.41
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,863.41	4,025,965.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,656,634.00	8,324,978.06	-23,713,629.75	00.00	67,267,982.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,089,047.16	00.00	8,089,047.16
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,656,634.00	8,324,978.06	-15,624,582.59	00.00	75,357,029.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,041,385.38	00.00	-17,041,385.38
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,656,634.00	235,930.90	-32,665,967.97	00.00	50,226,596.93
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,656,634.00	235,930.90	-32,665,967.97	00.00	50,226,596.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,656,634.00	235,930.90	-32,665,967.97	00.00	50,226,596.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	49,908,548.79	00.00	49,908,548.79
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,656,634.00	235,930.90	17,242,580.82	00.00	100,135,145.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	196,355,000.00	254,133,666.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,355,000.00	254,133,666.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,355,000.00	250,534,303.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	166,409,698.00
210101	Үндсэн цалин	00.00	142,244,321.00
210102	Нэмэгдэл	00.00	10,307,635.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	8,709,000.00
210104	Урамшуулал	00.00	5,148,742.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	10,710,283.73
210201	Тэтгэврийн даатгал	00.00	6,985,047.13
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	441,776.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	490,594.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	115,421.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,677,445.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	12,429,420.86
210301	Гэрэл, цахилгаан	00.00	584,392.86
210302	Түлш, халаалт	00.00	10,187,408.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,657,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	10,219,507.00
210401	Бичиг хэрэг	00.00	2,799,900.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,814,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	649,382.00
210404	Ном, хэвлэл	00.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	236,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	4,698,595.00
2105	Нормативт зардал	5,947,600.00	19,427,391.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,947,600.00	17,210,755.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,216,636.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	27,755,785.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	8,690,000.00
210602	Тавилга	00.00	9,771,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	5,814,500.00
210604	Урсгал засвар	00.00	3,479,585.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	168,100.00
210702	Дотоод албан томилолт	00.00	168,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,368,957.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	980,847.53

Дорноговь аймгийн Сайншанд Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	25,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	96,810.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190407400.00	2045160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	190,407,400.00	1,701,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	343,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3599363.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	3,599,363.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,599,363.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	196,355,000.00	258,140,768.26
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	196,355,000.00	196,355,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	196,355,000.00	196,355,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	10,187,408.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	10,187,408.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	22,188,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	22,188,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	29,409,760.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	29,409,760.26
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	18,863.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	4,025,965.55
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	12.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	07.00	07.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
Байхгүй.

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга О.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, аудитор Ш.Нарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн заслын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- Эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх;
- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ оношилгоо, шинжилгээ хийх
- Сумын хүн амын нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоог хангаж, орчны эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулах;

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/87 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална” (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 254,198.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,084.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,908.6 мянган төгрөгөөр буюу 99.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18.86	4,025.97	4,007.10
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	33,064.05	46,991.61	13,927.55
Үндсэн хөрөнгө	17,143.68	49,117.57	31,973.89
Нийт хөрөнгө	50,226.60	100,135.14	49,908.55
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	82,656.63	82,656.63	-
Хуримтлагдсан үр дүн	- 32,665.97	17,242.58	49,908.55
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	235.93	235.93	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	50,226.60	100,135.14	49,908.55

Бараа материалын тайлангийн үлдэгдэл 46,991.6 мянган төгрөг болж 13,927.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 2,081.5 мянга, эм боох материал 6,127.4 мянга, бичиг хэргийн материал 626.5 мянга, сэлбэг хэрэгсэл 120.0 мянга, түлш шатах тослох материал 133.5 мянга, аж ахуйн материал 5,078.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,973.9 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 19,161.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 17,157.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хандиваар ирснээс шалтгаалжээ.

Дорноговь аймгийн Сайншанд Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Биет бус хөрөнгийн дансанд 2020 оны тайлант хугацаанд ямар нэгэн материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй байна. Мөн 2020 онд өглөг, авлагагүй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 100,135.1 мянган төгрөг болж 49,908.6 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

2020 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого өмнөх оноос 153,904.0 мянган төгрөгөөр буюу 102 хувиар өссөн байна. Нийт зардал өмнөх оноос 86,144.9 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 283,616.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 283,616.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 87,261.7 мянган төгрөгөөр бууруулж, 196,355.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 196,355.0 мянган төгрөгийн төсөв баталж, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн, аймгийн Засаг даргын захирамж, ЭМД-ын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээрх санхүүжилт нийт 57,798.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогын 29,409.8 мянган төгрөгийн орлого оруулж, 254,133.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

№	Зардлын бүлгийн код	Зардлын бүлгийн нэр	2020 оны батлагдсан төсөв	Үүнээс: 2020 он		
				Зарцуулах эрх үүссэн	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү (+,-)
Урсгал зардлын тооцоо						
1	2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	131,145,900.00	131,145,900.00	166,409,698.00	- 35,263,798.0
2	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,725,340.00	12,725,340.00	10,710,283.73	2,015,056.3
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,210,000.00	2,210,000.00	12,429,420.86	- 10,219,420.9
4	2104	Хангамж, бараа материалын зардал	11,400,900.00	11,400,900.00	10,219,507.00	1,181,393.0
5	2105	Нормативт зардал, /Эм, нормын хувцас/	6,647,600.00	6,647,600.00	19,427,391.00	- 12,779,791.0
6	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,760,700.00	27,760,700.00	27,755,785.00	4,915.0
7	2107	Томиллолт зочны	240,000.00	240,000.00	168,100.00	71,900.0

Дорноговь аймгийн Сайншанд Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		зардал				
8	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,396,760.00	1,396,760.00	1,368,957.53	27,802.5
9	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,047,800.00	2,047,800.00	2,045,160.00	2,640.0
10	2131	Гадаад урсгал шилжүүлэг				-
11	2132	Бусад урсгал шилжүүлэг/нэг удаагийн тэтгэмж, урамшуулал/	780,000.00	780,000.00	3,599,363.00	- 2,819,363.0
Урсгал зардлын дүн			196,355,000.0	196,355,000.0	254,133,666.12	- 57,778,666.1

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 оны 149 мэдээллийг бүрэн мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан байна.

Тус онд шилэн дансанд мэдээлэх 149 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар түүвэрт хамрагдсан тул зөрчил, дүгнэлт байхгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30,275.7 мянган төгрөгийн зөрчилд 30,275.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, УСНББОУС, НБББББ-ийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 30,275.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын эргэлтийн болон үндсэн

хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байна.

Мөн УСНББОУС-ын дагуу тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, цалингийн зардалд шууд бичилт хийгдсэн байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". заалтуудыг зөрчсөн.

4.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгоно, татварын орлого дутуу бүрдэх;

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ-ын зүгээс хойшид анхаарч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорноговь аймгийн Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ДГА-2021/76/СТА-ТШЗ
Шалгагдагч байгууллагын нэр:		Сайншанд сумын Агатова өрхийн эмнэлэг	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/. НИЙТ ДҮН		Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Нягтлан бодогч	О.Уранчимэг, Ч.Оюунтүлхүүр